БАТЛАВ.
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГ СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН
ДАРГА Н.МӨНХЗУЛ

**"НҮҮДЭЛЧИН"** ДЭЛХИЙН СОЁЛЫН ФЕСТИВАЛД ОРОЛЦОГЧДЫН ХООЛ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 06 дугаар сарын 24 Дугаар: СУГ/20240103062 Улаанбаатар хот

| № | Ажлын нэр төрөл | Тайлбар |
|---|---|---|
| 1 | Ажил гүйцэтгэх хугацаа | 2024 оны 8 дугаар сарын 15-19-ний хооронд нийт 5 өдөр |
| 2 | Ажлын гүйцэтгэх байршил | Нийслэлийн Налайх дүүрэг, Улаанбаатар хотоос 50 км, Тайж хайрханы бэл |
| 3 | Ажлын код | СУГ/20240103062 |
| 4 | Хөрөнгө оруулалтын эх үүсвэр: | Улсын төсвийн хөрөнгө оруулалт |
| 5 | Захиалагч байгууллага: | ЗГХА-Соёл, урлагийн газар |
| 6 | Зөвшилцөх байгууллага: | Соёлын яам |
| **7** | Ажил гүйцэтгэх үндэслэл | - Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт<br>- Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, 16.5.5 дахь заалт<br>- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 32 дугаар 32.1, 32.2, 32.3 дахь хэсэг<br>- Нүүдэлчин" дэлхийн соёлын фестиваль зохион байгуулах тухай" 41 дүгээр тогтоол |

| | | |
|---|---|---|
| | | - Соёлын сайдын 2024 оны “Зардал баталж, эрх шилжүүлэх тухай” А/130 дугаар тушаал |
| 8 | Ерөнхий шалгуур үзүүлэлт | - 1000 ба түүнээс дээш хүн хүлээн авч үйлчлэх боломжтой байх<br>- Мөн тооны хүнд үйлчилгээ үзүүлэх хүлээн авалтын асар, ширээ, сандалтай байх<br>- Гадаадын зочид төлөөлөгчдөд 1 удаадаа 250 хүнд үйлчилгээ үзүүлэх асар, сандал ширээ, үйлчилгээний хэрэгсэлтэй байх<br>- Олон улсын оролцогчид, хүндэтгэл, ёслолын үеийн хоолны үйлчилгээг хариуцах |
| 9 | Шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад баримт | Тендерийн үнэд хоол хүнсний багцын үнийг иргүүлэх ба бусад угаалга цэвэрлэгээний материал, ажилчдын цалин бүх төрлийн татвар хураамж, даатгал, төлбөр тээвэр ***/хүнс тээвэр болон гарсан хог хаягдлыг тээвэрлэх зардал/*** болон бусад холбогдох зардлыг захиалагч тал хариуцахгүй.<br>Дараах бичиг баримтыг нотлох материал баримтын хамт бүрдүүлнэ.<br>1. Нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулах хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй байх<br>2. Олон улсын болон дотоодын томоохон арга хэмжээнд оролцож байсан туршлагатай.<br>3. Түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний гарал үүсэл, чанар,аюулгүй байдлын гэрчилгээ, шинжилгээний дүн зэргийг бүрдүүлэх<br>4. Нийт ажилчид нь эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамрагдсан байна<br>5. Худалдааны ажилтан нь лого, энгэрийн тэмдэг бүхий ажлын дүрэмт хувцастай, шууд халуунаар хэрэглэх хүнсний бүтээгдэхүүнээр үйлчлэхдээ амны хаалт, зориулалтын хэрэгслээр хангах |
| 10 | Цэвэрлэгээ, угаалга үйлчилгээ | • Фестивалийн ерөнхий төлөвлөгөөгөөр батлагдсан цэгт үйлдвэрлэл үйлчилгээ явуулах<br>• Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж буй орчны 50м талбайн хог хаягдлыг цэвэрлэх<br>• Хог хаягдлыг ангилан ялгах хогийн савыг асрын дотор болон гадна хэсэгт байршуулж, цэвэрлэгээ үйлчилгээг хариуцах<br>• Хоол, хүнсэнд хэрэглэж буй сав, баглаа боодлын шийдэл нь хүрээлэн буй орчинд ээлтэй хэлбэрээр шийдэх<br>• Хоол хүнсний бүтээгдэхүүний сав, баглаа боодлыг төвлөрсөн хогийн цэгт хаяж болохуйц овор хэмжээтэй, гадуураа хогийн уутай байх |

| | | |
|---|---|---|
| | | • Шингэрүүлсэн шатдаг хий ашиглах тохиолдолд аюулгүй ажиллагааг хангах |
| 11 | Техник хэрэгслийн мэдээлэл | • Бэлэн болон хагас боловсруулсан бүтээгдэхүүн, түүхий эдийг тус тусад нь зориулалтын хөргөх төхөөрөмжид хадгалах нөхцөл бүрдүүлэх<br>• Хоол хүнсэнд хэрэглэж буй нэг удаагийн хэрэгсэл /хоолны сав, сэрээ, халбага/ нь эрүүл ахуйн шаардлага, стандартад нийцсэн байх<br>• Хүнсний зориулалтын сав, баглаа боодол хэрэглэх<br>• Хүнс, түүхий эдийг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх<br>• Хоол үйлдвэрлэлийн технологийн шат дамжлагыг нэг чигийн урсгалтай байхаар зохион байгуулах<br>• Бараа, бүтээгдэхүүний хадгалалтын горимыг хангасан, зориулалтын тоног төхөөрөмж, ашиглах |
| 12 | Аюулгүй байдал | • Фестивалийн ерөнхий төлөвлөгөөгөөр батлагдсан цэгт үйлдвэрлэл үйлчилгээ явуулах<br>• ХАБЭА-н дүрэм журам өдөр бүрийн батлагдсан зааварчилгаатай байх<br>• Үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагааг хянах мэдээлэл солилцох бүртгэл жагсаалт хөтлөх маягттай байх<br>• Хортон шавьжаас урьдчилан сэргийлэх устгах арга хэмжээ авах |

Хянасан:

Бүх нийтийн соёл, урлаг, уран бүтээлийн хэрэгжилтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Дэлгэрмаа

Соёл, соёлын өвийн хэрэгжилтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Ууганцэцэг

Боловсруулсан:

Соёл, соёлын өвийн хэрэгжилтийн газрын мэргэжилтэн Ч.Дариймаа